МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр Дугаар А/168 Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан 2022 оны контрактыг дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Ажлын хэсгийн дэд дарга: (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:
(Орон нутгийн өмчийн газрын дарга)
(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)
(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хяналт хариуцсан мэргэжилтэн)
(Орон нутгийн өмчийн газрын өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)

2.

(Үйлдвэрийн газрын захирлууд)

(Үйлдвэрийн газрын нягтлан бодогч нар)

Нарийн бичгийн дарга: (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захирлуудтай байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор багтаан дүгнэж, санал дүгнэлт боловсруулан, дүнг аймгийн Засаг даргын Удирдлагын Зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР